

Өвдөлтийн талаарх мэдлэг хандлагын үнэлгээний асуумжын Монгол хувилбарын хүчин төгөлдөр болон найдвартай байдлыг тодорхойлсон дүн

Т.Батцэцэг¹, Д.Нямаа¹, Ч.Энхтуул¹, Х.Баяржаргал², С.Энхтүвшин³, Р.Оргилмаа¹

¹АШУҮИС, СС, Насанд хүрэгчдийн сувилахуйн тэнхим

²АШУҮИС, СС

³Гранд Мед эмнэлэг, ӨМ

Цахим ирүүд: gnu23e001@gt.mn.ums.edu.mn, Утас: 88847181

Түлхүүр үг:

Өвдөлт
Мэдлэг
Хандлага

Товч утга:

Үндэслэл: Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд сувилагч нар эмчлүүлэгчтэй хамгийн их цагийг зарцуулдаг тул оновчтой зөв эмчилгээ хийхэд гол тулгуур нь болдог гэж судлаачид үздэг байна. Сувилагчийн үнэлгээний ур чадвар нь өвдөлт намдаахад чухал үүрэг гүйцэтгэдэг ба эмнэлэгт хэвтэх үеийн өвдөлтийг тодорхойлдог. Өвдөлтийн талаарх сувилагч нарын мэдлэг, хандлага нь дадлага туршлагыг нэмэгдүүлэх гол түлхүүр болж, өвдөлтийг аль болох үр дүнтэй зохицуулах, физиологийн сэтгэл зүйн хямралаас урьдчилан сэргийлэх боломжийг олгодог гэж судлаачид дурдсан байна. Сувилагч нарын өвдөлтийн талаарх мэдлэг хандлагыг үнэлэх асуумжын монгол хувилбарын хүчин төгөлдөр болон найдвартай байдлыг тодорхойлсон судалгааны ажил харьцангуй цөөн байгаа нь энэхүү судалгааг хийх үндэслэл боллоо. **Зорилго:** Өвдөлтийн талаарх мэдлэг хандлагийн үнэлгээний асуумжын монгол хувилбарын хүчин төгөлдөр болон найдвартай байдлыг тодорхойлох. **Арга, аргачлал:** Судалгааг агшингийн загвараар, тоон судалгааны аргаар Өвдөлтийн талаарх мэдлэг, хандлагыг үнэлэх асуумжын хуудсыг ашиглан хийв. Судалгаанд УНТЭ, УХТЭ, УГТЭ-ийн мэс засал, яаралтай тусламж, эрчимт эмчилгээний тасгийн 145 сувилагчийг хамруулав. Статистик боловсруулалтыг SPSS-25.0 программ ашиглан хийсэн. **Үр дүн:** Бидний судалгаанд 115 эмэгтэй, 30 эрэгтэй сувилагч хамрагдсан ба дундаж нас нь 37.21 ± 7.50 жил ажилласан хугацаа нь дунджаар 13.43 ± 7.57 жил байв. Харагдах байдлын индекс асуумж тус бүрээр FVI 0.81-1.00 байсан. Агуулгын хүчин төгөлдөр байдлын индекс асуулт тус бүрээр авч үзвэл CVI 0.66-1.00 хооронд байсан. Асуумжын дотоод найдвартай байдал Кронбах альфа 0.88 байв. **Дүгнэлт:** Өвдөлтийн талаарх мэдлэг хандлагийн үнэлгээний асуумжын монгол хувилбар нь асуумжийн харагдах байдал, агуулга болон найдвартай байдал зэрэг нь хангалттай тодорхойлогдсон тул цаашид практикт ашиглах боломжтой гэж үзэж байна.

Үндэслэл: Өвдөлт нь хүн бүрт тохиолдож болох нийтлэг мэдрэмж бөгөөд цочмог өвдөлт нь эмнэлгийн тусламж авах шалтгаан болдог гэж судлаачид тодорхойлсон байна.¹ Сувилагч нар өвдөлтийг олон талаас нь үнэлж, менежмент хийхийн тулд олон мэргэжлийн багаар хамтран ажиллаж үйлчлүүлэгчийн зовиурыг багасгадаг.² Өвдөлт гэдэг нь хэт хүчтэй ба гэмтээгч цочролоор үйлчлэхэд үүссэн үйл ажиллагааны хямралын улмаас бий болсон хүний

сэтгэц физиологийн өвөрмөц байдлыг хэлдэг байна.³

Олон улсын өвдөлт судалын холбооноос (International Association for Study of Pain IASP) 2020 оны шинэчилсэн тодорхойлолтоор өвдөлт гэдэг нь “Эдийн гэмтэлтэй холбоотой, эсвэл холбоогүйгээр үүсч буй мэдрэхүйн болон сэтгэлийн таагүй мэдрэмж” юм.⁴ Энэ тодорхойлолтод дараах нэмэлт заалтуудыг багтаан авч үзсэн үүнд:

- Өвдөлт хувь хүн болгонд өөр өөр мэдрэгдэх

бөгөөд өвдөлт үүсэхэд биологийн, сэтгэлзүйн, нийгмийн хүчин зүйлүүд нөлөөлнө.

- Хүний амьдралын бүхий л үе шатанд өвдөлт мэдрэгдэж болно.
- Өвдөлт гэсэн зовиуртай байгаа хүнийг анхааран үзэх шаардлагатай.
- Өвдөлтөд хүн дасан зохицдог ч хүний үйл ажиллагаа, нийгэм, сэтгэл зүйн сайн сайхан байдалд сөргөөр нөлөөлж байдаг.

Өвдөлт нь ихэвчлэн эдийн гэмтлээс үүдэлтэй, амьдралын хэвийн үйл ажиллагааг алдагдуулж, эмчлүүлэгчийг эмчид хандахад хүргэдэг таагүй шинж тэмдэг юм. Энэ нь эрүүл мэндтэй холбоотой амьдралын чанарт сөргөөр нөлөөлж, бие махбодын, сэтгэл хөдлөлийн, нийгмийн үйл ажиллагааг доройтуулдаг. Өвдөлтийг зөв, найдвартай үнэлэх нь түүнийг үр дүнтэй намдаах төлөвлөгөө боловсруулах эхний чухал алхам болно гэж судлаачид онцлон тэмдэглэсэн байна.⁵

Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд сувилагч нар эмчлүүлэгчтэй хамгийн их цагийг өнгөрөөдөг тул зөв оновчтой эмчилгээ хийхэд гол тулгуур нь болдог байна. Сувилагчийн үнэлгээний ур чадвар нь өвдөлт намдаахад чухал үүрэг гүйцэтгэдэг ба эмнэлэгт хэвтэх үеийн өвдөлтийг тодорхойлдог.⁶ Өвдөлтийн талаарх сувилагч нарын мэдлэг, хандлага нь дадлага туршлагыг нэмэгдүүлэх гол түлхүүр болж, өвдөлтийг аль болох үр дүнтэй зохицуулах, физиологийн сэтгэл зүйн хямралаас урьдчилан сэргийлэх боломжийг олгодог гэж судлаачид дурдсан байна.⁷

Өвдөлт намдаах талаар сувилагчдын мэдлэг, хандлагыг үнэлэх судалгаа олон улсын хэмжээнд хэд хэдэн удаа хийгдсэн бөгөөд сувилагч нар өвдөлт намдаах талаар хангалттай мэдээлэлгүй байгааг онцолсон байдаг.⁸

Өвдөлтийн талаарх мэдлэг, хандлагыг үнэлэх олон асуумжууд байдгаас хамгийн түгээмэл хэрэглэгддэг нь 1987 онд Феррелл ба МакКаффеи нарын боловсруулсан Өвдөлтийн талаархи мэдлэг, хандлагыг үнэлэх асуумж (Knowledge and Attitudes Survey Regarding Pain -KASRP, ӨТМХҮА) юм.⁹⁻¹¹ ӨТМХҮА-ийн агуулга нь Олон улсын Өвдөлтийн нийгэмлэг, ДЭМБ-ын өвдөлтийн менежментийн удирдамжын дагуу удаа дараа шинэчлэгдэн сайжирсаар ирсэн. Өвдөлтийн мэргэжилтнүүдийн баг агуулгын хүчин төгөлдөр байдал, найдвартай байдлыг судалсан (Кронбах альфа >0,70). ӨТМХҮА нь олон оронд орчуулагдаж баталгаажсан байна.

Сувилагч нарын өвдөлтийн талаарх мэдлэг хандлагыг үнэлэх асуумжын монгол хувилбарын хүчин төгөлдөр болон найдвартай байдлыг тодорхойлсон судалгааны ажил харьцангуй цөөн байгаа нь энэхүү судалгааг хийх үндэслэл боллоо.

Зорилго: ӨТМХҮА-ын Монгол хувилбарын хүчин төгөлдөр болон найдвартай байдлыг тогтоож сувилагч нарын өвдөлтийн талаарх мэдлэг, хандлагыг үнэлэх.

Арга, аргачлал: Бид судалгааг агшингийн загвараар, тоон судалгааны аргаар Өвдөлтийн талаархи мэдлэг, хандлагыг үнэлэх (ӨТМХҮА- 39 асуумж, хүн ам зүйн

10 асуумж бүхий нийт 49 асуулттай асуумжын хуудсыг ашиглан хийв. Судалгаанд УНТЭ, УХТЭ, УГТЭ-ийн мэс засал, яаралтай тусламж, эрчимт эмчилгээний тасгийн 145 сувилагчийг хамруулав. ӨТМХҮА-ын 2014 оны Англи хэл дээрх хувилбарыг ДЭМБ-ын удирдамжын дагуу орчуулсан. Статистик боловсруулалтыг SPSS-25.0 программ ашиглан хийсэн. Орчуулсан хувилбарын харагдах байдлын хүчин төгөлдөр байдал (Face validity), агуулгын хүчин төгөлдөр байдал (Content validity)-д үнэлгээ хийсэн. Агуулгын хүчин төгөлдөр байдлыг “Агуулгын Хүчинтэй Байдлын Индекс”-ээр (Content Validity Index-CVI) тодорхойлов. I-CVI индекс 0.8-аас дээш байгаа тохиолдолд агуулгын хүчин төгөлдөр байдал найдвартай гэж үзсэн. Харагдах байдлын хүчин төгөлдөр байдлыг “Харагдах байдлын хүчинтэй байдлын индекс”-ээр (Face validity index-FVI)-ээр тодорхойлсон. FVI-г асуумж тус бүр дээр 0-1 оноогоор дүгнэсэн. Асуумжын дотоод найдвартай байдал (Internal consistency) -ыг Кронбах альфа утгаар тодорхойлсон ба 0.7-с дээш тохиолдолд найдвартай гэж үзсэн.

Судалгааны ажлын ёс зүй: УНТЭ, УХТЭ, УГТЭ -ээс судалгаа хийх зөвшөөрөл авч судалгааны арга аргачлалыг АШУҮИС-ын Судалгааны ёс зүйн хяналтын хорооны 2024.03.22-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн судалгаа эхлүүлэх зөвшөөрөл (N2024/3-03) авсан болно. Судалгаанд хамрагдагчдаас таниулсан зөвшөөрлийн хуудсаар дамжуулан судалгаанд хамрагдах зөвшөөрөл авсан.

Үр дүн: Асуумжын найдвартай байдлыг нийт 115 эмэгтэй, 30 эрэгтэй сувилагчийг хамруулан судлахад дундаж нас нь 37.21 ± 7.50 жил ажилласан хугацаа нь дунджаар 13.43 ± 7.57 жил байв. Судалгаанд хамрагдсан сувилагч нарын 81% нь бакалаврын боловсролтой, 6% нь магистрын зэрэгтэй, мэргэжлийн зэргийн хувьд 27% нь ахлах, 16% нь тэргүүлэх, 1% нь зөвлөх зэрэгтэй байсан. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдагсдын хүн ам зүйн мэдээлэл

Хүн ам зүйн мэдээлэл	Дундаж $\pm$ СХ
Нас (жилээр)	37.21 $\pm$ 7.50
Ажлын туршлага (жилээр)	13.43 $\pm$ 7.57
Хүн ам зүйн мэдээлэл	Давтамж (Хувь)
Боловсролын түвшин	
Диплом	19 (13)
Бакалавр	118 (81)
Магистр	8 (6)
Эмнэлэг	
УНТЭ	65 (45)
УХТЭ	21 (15)
УГТЭ	59 (41)
Мэргэшлийн зэрэг	
Мэргэжилийн зэрэг аваагүй	81 (56)
Ахлах	39 (27)
Тэргүүлэх	23 (16)
Зөвлөх	2 (1)

Харагдах байдлын хүчин төгөлдөр байдал: Харагдах байдлын индекс асуумж тус бүрээр FVI 0.81-1.00

байсан ба ӨТМХҮА-ын ерөнхий FVI-0.92 буюу хүчин төгөлдөр гэж тодорхойлогдлоо. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Агуулгын хүчин төгөлдөр байдалд шинжээч нарын өгсөн зөвлөмж

Асуумжын дугаар	Агуулга	Шинжээчийн зөвлөгөө
16	Викодин (гидрокодон 5мг + ацетаминофен 300мг) (уух хэлбэр) өвдөлт намдаах эм нь ойролцоогоор морфин (уух хэлбэр)-ийн 5-10мг тунтай тэнцдэг.	Викодин Монголд ховор тул Трамадолоор солих
20	Мансууруулах төрлийн (нойрны) эмэнд донтох нь эмийн зохисгүй хэрэглээ, муу зуршилд автах, хор хөнөөл учруулсан ч ... нейробиологийн өвдөлт гэж үзэхэд хүрдэг.	Нейробиологийн гэдэг үгийг засах
28	Хавдрын зовууртай эмчлүүлэгч 2 сарын турш өдөр бүр мансууруулах төрлийн өвдөлт намдаах эмийг хэрэглэдэг.	Энэ асуулт тодорхой тоог санахыг шаардаж байгаа тул хасах санал оруулж байна
30	Хавдрын зовуурийн үед хийх эмчилгээнд аль нь таарах вэ? а) Ибупрофен (Морфин).....	Гидроморфон Монголд ховор тул хасах
32	Өвдөлттэй эмчлүүлэгчид анхаарал халамж тавихдаа соёлын талаар анхаарах хамгийн сайн арга барилыг аль нь тодорхойлсон байна вэ?	Монгол соёлд тулгуурлан өөрчлөх эсвэл хасах
38, 39	Эмнэлзүйн тохиолдол	Эмнэлзүйн тохиолдлыг Монгол хүний нэрээр өөрчлөн Англи товчлолуудыг монголоор бичих

Агуулгын хүчин төгөлдөр байдал: ӨТМХҮА-ын Монгол хувилбарыг эх хувилбараас мэргэжлийн 2 орчуулагч Монгол хэл рүү хөрвүүлэн эргэж эх хэл рүү орчуулан утгын алдаа гарсан эсэхийг шалгасан болно. Энэ үед 2 орчуулагчын хувилбаруудад хэд хэдэн ялгаатай байдал ажиглагдсан бөгөөд орчуулагчид, судалгааны багтай хамтарч эцсийн хувилбарыг гаргасан. Түүнчлэн 3 шинжээч агуулгын найдвартай байдлыг үнэлсэн. Агуулгын хүчин төгөлдөр байдлын индекс асуулт тус бүрээр авч үзвэл CVI 0.66-1.00 хооронд байсан. 36 асуумжын CVI өндөр буюу 1.00 байсан бол 16, 20, 28, 32, 33-р асуумжын CVI оноо бага буюу 0.66 гарсан. Асуумжын ерөнхий CVI 0.92 асуумжын дотоод найдвартай байдал Кронбах альфа 0.88 байв.

Хэлцэмж: Эрүүл мэндийн ажилтнууд өвдөлтийн талаар мэдлэг хангалттай байх нь өвчтөнд өвдөлтийн менежментийг зөв оновчтой хийхэд чухал ач холбогдолтой. ӨТМХҮА-ын анхны хувилбар нь Англи хэл дээр 1987 онд эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн өвдөлтийн талаарх мэдлэг, хандлагыг үнэлэх зорилгоор боловсруулагдсан байдаг. Ингээд 2014 онд шинэчлэн сайжруулалт хийгдсэн байна.¹¹ ӨТМХҮА-нь олон оронд орчуулагдан найдвартай байдал нь баталгаажсан асуумж юм. Бид ӨТМХҮА-ын Монгол хувилбарыг гаргахын тулд үе шаттай орчуулга, харагдах байдлын хүчин төгөлдөр байдал, агуулгын хүчин төгөлдөр байдал, дотоод найдвартай байдлыг үнэллээ. Бидний судалгаагаар CVI индекс 0.66-1.00-ийн хооронд тодорхойлогдсон ба асуумжын ерөнхий CVI 0.90 нь агуулгын хүчин төгөлдөр байдал найдвартай байгааг харуулж байна. Судлаач Thi NN (2023) нарын судалгаагаар Вьетнам хувилбарын CVI индекс 0.83-1.00, S-CVI -0.996 гэж тодорхойлогдсон нь бидний судалгааны үр дүнтэй дүйж байлаа.¹² Судлаач

Yu W (2020) нарын Хятад хувилбарын S-CVI-0.97, CVI-ийн утга 0.0-1.00¹³ мөн бидний судалгааны ажилтай ойролцоо байлаа, судлаач Kwon S-H (2020) нарын судалгаанд Солонгос хувилбарын I-CVI-ийн утга 0.73-1.00⁹ байсан бол Maneewat K (2025) нарын хийсэн S-CVI-0.90, CVI-ийн утга 0.67-1.00¹⁴ байсан нь бидний судалгааны үр дүнтэй тус тус ойролцоо байлаа. Асуумжын дотоод найдвартай байдал Кронбах альфа 0.88 тодорхойлогдсон нь дотоод найдвартай байдал Вьетнам хувилбар¹² болон анхны хувилбарыг боловсруулсан Феррел¹¹ нарын судалгаатай ойролцоо байлаа.

Дүгнэлт: Өвдөлтийн талаарх мэдлэг хандлагийн үнэлгээний асуумжын монгол хувилбар нь асуумжийн харагдах байдал, агуулга, болон найдвартай байдал зэрэг нь хангалттай тодорхойлогдсон тул практикт ашиглах боломжтой гэж үзэж байна.

Ном зүй:

1. Egert A, Lee K, Gill M. *Nursing Fundamentals. Fundamentals of Nursing Pharmacology-Mohawk College Edition.* 2023.
2. for Nursing OR, Ernstmeier K, Christman E. *Scope of Practice. Nursing Fundamentals [Internet]: Chippewa Valley Technical College;* 2021.
3. Malakowsky LM. *Perioperative Pain Control: Evaluating Best Practices in Perioperative Pain Measures,* Andrews University; 2023.
4. Truini A, Aleksovska K, Anderson CC, et al. *Joint European Academy of Neurology-European Pain Federation-Neuropathic Pain Special Interest Group of the International Association for the Study of Pain guidelines on neuropathic pain assessment. European Journal of Neurology.* 2023;30(8):2177-2196.
5. Eaton LH, Meins AR, Mitchell PH, Voss J, Doorenbos AZ. *Evidence-based practice beliefs and behaviors of nurses providing cancer pain management: A mixed-methods approach. Paper presented at: Oncology nursing forum*2015.
6. Shuaib N. *Nurses knowledge regarding pain management among patients in critical care units. J Clin Anesthesiol.* 2018;2(2):106.

7. Habich M, Wilson D, Thielk D, et al. Evaluating the effectiveness of pediatric pain management guidelines. *Journal of pediatric nursing*. 2012;27(4):336-345.
8. Sigakis MJ, Bittner EA. Ten myths and misconceptions regarding pain management in the ICU. *Critical care medicine*. 2015;43(11):2468-2478.
9. Kwon S-H, Kim H, Park S, Jeon W. Development of knowledge and attitudes survey on pain management for Korean long-term care professionals. *Asian Nursing Research*. 2020;14(2):105-113.
10. Ung A, Salamonson Y, Hu W, Gallego G. Assessing knowledge, perceptions and attitudes to pain management among medical and nursing students: a review of the literature. *British journal of pain*. 2016;10(1):8-21.
11. Ferrell B, McCaffery M. Knowledge and attitudes survey regarding pain. *City of Hope Pain & Palliative Care Resource Center*. 2014.
12. Thi NN, Tuan AT, Huy HD, et al. Validity and Reliability Measurement of the Knowledge and Attitude Survey Regarding Pain Tool Vietnamese Version. *International Journal of Medical Science and Clinical Research Studies*. 2023;3(3):504-518.
13. Yu W, Li D, Lu Y, Yang H, Ma X. Knowledge and attitudes of Chinese oncology nurses regarding cancer pain management—a cross-sectional study. *Journal of Cancer Education*. 2021;36:1115-1123.
14. Maneewat K, Nimmaanrat S, Thepsuwan A, Srisintorn W, Siripituphum D, Jensen MP. Validity and Reliability of the Thai Version of the Knowledge and Attitudes Survey Regarding Pain (Thai KASRP). *Journal of Health Science and Medical Research*. 2025:20251145.

Validity and Reliability Measurement of the Knowledge and Attitude Survey Regarding Pain Tool Mongolian Version

Battsetseg T¹, Nyamaa D, Enkhtuul Ch, Bayarjargal Kh², Enkhtuvshin S³, Orgilmaa R¹

¹Department of Adult school of nursing, NNUMS

²School of nursing NNUMS

³Department of Pain Management, Grand Med Hospital

E-mail: gnu23e001@gt.mnums.edu.mn, Tel: +976-88847181

Background: Nurses spend the most time with patients when providing medical care, making them a crucial factor in ensuring appropriate and effective treatment. Their assessment skills play a vital role in pain management.

Aim: This study aims to determine the validity and reliability of the Mongolian version of the Knowledge and Attitudes Survey Regarding Pain (KASRP).

Materials and Methods: A cross-sectional, quantitative study was conducted using the Knowledge and Attitudes Survey Regarding Pain (KASRP) questionnaire. A total of 145 nurses from the surgical, emergency, and intensive care units of the National Trauma and Orthopedic Research Center (NTORC), the National Cancer Center of Mongolia (NCCM), and the National Center for Maternal and Child Health (NCMCH) participated in the study. Statistical analysis was performed using SPSS-25 software.

Results: The study included 115 female and 30 male nurses, with an average age of 37.21±7.50 years and an average work experience of 13.43±7.57 years. The face validity index (FVI) for each item ranged from 0.81 to 1.00. The content validity index (CVI) for each item ranged from 0.66 to 1.00. The internal consistency of the questionnaire was assessed using Cronbach's alpha, which was found to be 0.88.

Conclusion: The Mongolian version of the KASRP demonstrates satisfactory face validity, content validity, and reliability, making it suitable for practical application.

Keywords: Pain, Knowledge, Attitude